



“Дарханы Төмөрлөгийн Үйлдвэр” ХХК
Дархан-Уул аймаг, Дархан сум, 16-р баг,
Дарханы Төмөрлөгийн Үйлдвэр ХХК,
206 тоот өрөө
Утас/факс: 7509-0044
Вэбсайт: www.dmp.mn

“Дарханы Төмөрлөгийн Үйлдвэр” ХХК-д шаардлагатай
шууд худалдан авалтын зар **№51**

Төсөвт өртөг: 15,500,000 төгрөг

2026.03.04

№	Бараа ажил, үйлчилгээний нэр	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Үзүүлэлт
1	“Нийт ажилтны ХЭМАБ сургалт”	багц	1.0	ХАБЭА тухай хуулийн 17.4-ийн хэрэгжилтийг хангах. Бүх төрлийн ажлын байранд ажиллах ажилтнууд аюулгүй ажиллах, ажлын байрны сөрөг хүчин зүйлсээс эрүүл мэндээ хамгаалахад зайлшгүй шаардлагатай ХАБЭА-н суурь болон хууль эрх зүйн ойлголт, мэдлэгтэй болно

**“Дарханы Төмөрлөгийн Үйлдвэр” ХХК-иас шууд худалдан авалтаар ажил, үйлчилгээ
гүйцэтгүүлэх тухай ажлын даалгавар**

1. Ерөнхий мэдээлэл

Захиалагч байгууллага: ДТҮ ХХК

Бараа, ажил, үйлчилгээний нэр: “Нийт ажилтны ХЭМАБ сургалт”

2. Худалдан авах үйлчилгээний зорилго

ХАБЭА-ны тухай хуулийн 28.1.4-ийн хэрэгжилтийг хангах

3. Сургалтын хамрах хүрээ, зохион байгуулалт

- Нийт 1634 ажилтныг хамруулсан сургалтыг 3, 4 саруудад эхний ээлжийн сургалтыг 9, 10 дугаар саруудад дараагийн ээлжийн сургалтыг зохион байгуулна.
- Сургалтыг зохион байгуулах бүрдээ оролцогчдын тооноос хамааруулан 6 ээлжээр явуулах бөгөөд нийт 12 удаагийн сургалт зохион байгуулна.
- Сургалтыг танхимын хэлбэрээр зохион байгуулна.
- Багш нарын зам, байр, хоол зэрэг томилолтын бүх зардлыг сургалтын байгууллага өөрөө хариуцна.

4. Гүйцэтгэгчид тавигдах шаардлага ба бүрдүүлэх материал

Сургалтын үйлчилгээ үзүүлэгч нь дараах шаардлагыг хангасан байна:

- Сургалтын байгууллага нь хуулийн этгээд байх бөгөөд тухайн чиглэлээр мэргэшсэн багшлах хүний нөөцтэй байна.

- Холбогдох чиглэлээр сургалт явуулах **тусгай зөвшөөрөлтэй**, сургалт зохион байгуулж байсан туршлагатай байх
- Холбогдох хууль, журмын шаардлагад нийцсэн, тухайлбал **Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам-ны сайдын А/130 тушаалын 1 дүгээр хавсралтад заасан хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сургалт зохион байгуулах журам**-ын шаардлагыг хангасан, ажлын байрны онцлогт тохируулсан сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөтэй байна.
- Багш нь тухайн чиглэлээр мэргэшсэн, заах арга зүйн чадвартай, шаардлагатай мэргэжлийн туршлага, гэрчилгээтэй байна.
- Сургалтыг онол, дадлагыг хослуулсан, стандарт шаардлага хангасан сонирхолтой, интерактив арга зүйгээр зохион байгуулна.

5. Төлбөрийн нөхцөл

- Урьдчилгаа төлбөр олгохгүй.
- Гэрээт ажлын төлбөр болох **100 хувь буюу 15,500,000 төгрөгийг** сургалтын байгууллага гэрээний дагуу бүх ажлыг бүрэн гүйцэтгэж, талууд ажлыг актаар хүлээлцсэний дараа, гүйцэтгэгчийн нэхэмжлэхийг үндэслэн шилжүүлнэ.

6. Гүйцэтгэх хугацаа

- Гэрээ батлагдсаны дараа гүйцэтгэх хугацааг талууд харилцан тохиролцож тогтооно.
- Захиалагч талаас сургалтын товыг урьдчилан мэдэгдэнэ.
- Гүйцэтгэгч нь товлосон хугацаанд сургалтыг зохион байгуулна.
- Гүйцэтгэх хугацааг тооцохдоо **хуанлийн өдрийг** баримтална.

**Үнийн санал хүлээн авах сүүлийн хугацаа:
2026 оны 03 дугаар сарын 06-ны өдрийн 17 цаг 00 минут хүртэл**

Шууд худалдан авалттай холбоотой тодруулга
болон үнийн санал хүлээн авах хаяг:
Худалдан авалтын хэлтэс
/procurement@dmp.mn/
Утас: 7509-0044